

**“Нако түлш” ХК-ийн 2015 оны хагас жилийн  
үйл ажиллагааны тайлан**

Компанийн нэр: ”Нако түлш” ХК

Хаяг: Дархан-Уул аймаг, Дархан сум, Үйлдвэрийн хотхон 13-р баг

Утас:70379006

Улсын бүртгэлийн дугаар:	1910001019
Регистрын дугаар:	4489969
Үйл ажиллагааны чиглэл:	Хагас коксон утаагүй түлшний үйлдвэрлэл
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	128 /2015.03.06-ны байдлаар/

Үйл ажиллагааны тайлан:

“Нако түлш” ХК 2015 оны хагас жилийн байдлаар дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

Үйлдвэрийн агааржуулалт салхивчийн зургийг мэргэжлийн зураг төсвийн байгууллагаар хийлгэн, зургийн дагуу угсралт суурилуулалтын ажлыг хийж дуусган ажилд бэлэн болгосон.

Коксын хос зуухны дотор бортогоны усны шугамыг хөргөлтийн усан сангийн насосны шугамтай холбох, элеватороос зуухны орой дээр байрлах бункерийг холбосон нүүрсний гулсуур болон зуух ачаалагч операторын өрөөг шинээр барих, тоноглох, зуухны дээд тальны замыг сунгах, зуухны дээд бункерүүдэд гидро шахуургатай автомат хаалт хийх зэрэг ажлуудыг хийж гүйцэтгээд байна.

Уурхайгаас нүүрс ирэх хугацаанд үйлдвэрийн барилгын дотор шороон хэсэгт бүхэл хайрга дэвсэж, шал цутгах ажлыг хийснээр үйлдвэрийн барилгын шалыг бүхэлд нь бетон болгоод байна.

Бид 2-р улиралд хийхээр төлөвлөсөн засвар шинэчлэлийн ажлуудаа дуусган 2015.05.21-ний өдөр нэгдүгээр зуухаа асаасан.

2015.05.13-05.19-ний хооронд Шарын голын уурхайгаас 1001.6 тонн нүүрс хүлээн авч хэт том бүхээллэгийг бутлан, чулууг ялгаж 25мм-ээс доош фракц 251 тонн, 25-100мм фракц 334.7 тонн, 100мм-ээс дээш фракц 251 тонн, нийт 836.7 тонн нүүрсийг зууханд оруулсан.

Зуухнаас 25мм-ээс доош фракц 270 тонн, 25мм-ээс дээш фракц 180 тонн, нийт 450 тонн хагас кокс гарсан бөгөөд хагас коксын гарц 53.8 хувьтай байна.

Шинээр гарсан хагас коксоос 1.5тн-ийг брикетлэн /шахмал түлш/ хийн хатааж мэргэжлийн хатуу түлш шинжилгээний лабораторид өгч шинжлүүлсэн. Бид цаашид угаасан нүүрсээр хагас кокс хийхээр төлөвлөн ажиллаж байна.

Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд:

Тус компани нь 2015 оны 06-р сарын 30-ны өдрөөр дуусгавар болгон санхүү байдлын тайлан, орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан тэнцлээ

Олон улсын стандарт болон Монгол Улсын нягтлан бодох бүртгэлийн хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар, аргачлалаар мөрдөж байгаа хууль тогтоомжийн дагуу гарган санхүү, татварын байгууллага болон холбогдох бусад газруудад тушаасан.

Компанийн 2014, 2015 оны жилийн орлогын тайлангийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Үзүүлэлт	2014 он	2015 он
Борлуулалт	110550.6	2908.5
Борлуулсан бүтээгдэхүүний өртөг	185592.5	1657.3
Нийт ашиг	-75041.9	1251.2
Үйл ажиллагааны бус орлого	4727.5	19.2
Үйл ажиллагааны зардал	283375.2	148371.8
Үйл ажиллагааны бус зардал	51512.3	180.2
Татвар төлөхийн өмнөх ашиг/алдагдал	-405201.9	-147281.6
Орлогын татварын зардал	38.2	114.6
Цэвэр ашиг, алдагдал	-405240.1	-147396.2

Үйл ажиллагааны борлуулалтын орлого 2015 онд “Силикат” ХК-д 67,7 тн нүүрс борлуулсан байна.

Цалин хөлсний зардалд 43140,9 мянган төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 7222,7 мянган төгрөг, ашиглалтын зардалд 1339,4 мянган төгрөг, түлш шатахуун, тээврийн хөлс сэлбэг хэрэгслийн зардалд 576,9 мянган төгрөг, ХХОАТ 4129,8 мянган төгрөг тус тус зарцуулсан байна.

Компанийн 2014 он, 2015 оны хөрөнгө, эх үүсвэрийн тэнцлийн үзүүлэлтээс зэрэгцүүлэн үзвэл:

Хөрөнгө өр төлбөрийн үзүүлэлтүүд	2014 он	2015 он
Эргэлтийн хөрөнгө	595958,3	619666,7
Эргэлтийн бус хөрөнгө	2909308,8	2897951,7
Нийт хөрөнгийн дүн	3505267,1	3517618,4
Богино хугацаат өр төлбөр	1045310,2	1197192,8
Урт хугацаат өр төлбөр	695224,7	797686,2
Эзэмшигчийн өмчийн дүн	1764732,2	1522739,4
Өр төлбөр, эзэмшигчийн өмчийн дүн	3505267,1	3517618,4

Ноогдол ашгийн талаарх мэдээлэл:

Компани 2014 онд алдагдалтай ажилласан тул ноогдол ашиг тараагаагүй болно.

Үнэт цаас гаргагчийн хяналтын багц эзэмшигчдийн болон ТУЗ-ийн мэдээлэл:

Компани их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл хийгээгүй. Компанийн хяналтын багц эзэмшигчдийн хувьд өөрчлөлт ороогүй.

Компанийн хяналтын багц эзэмшигчдийн мэдээлэл

№	Овог нэр	Албан тушаал	Хувьцааны хувь
1	Шарын Гол ХК	Нүүрс олборлолт	92,93%

Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр Б.Батбаатар, Грам Чапман, Б.Баярбат, Ж.Эрдэмбилэг, Д.Даянбилгүүн, Б.Лхагвадорж, хараат бус гишүүдээр Д.Нарангоо, Т.Тамир, Д.Түвшинтөгс нар ажиллаж байна.

Үнэт цаас гаргагчийн удирдлага, эрх бүхий албан тушаалтны танилцуулга:

№	Овог нэр	Албан тушаал	Эрхэлж буй ажил	Боловсрол
1	Б.Батбаатар	ТУЗ-ийн дарга, ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
2	Грамм Чапман	Ердийн гишүүн	Шарын гол ХК-ийн ТУЗ-ийн гишүүн	Дээд
3	Б.Баярбат	Ердийн гишүүн	Нако Түлш ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
4	Ж.Эрдэмбилэг	Ердийн гишүүн	СВМ ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
5	Д.Даянбилгүүн	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
6	Б.Лхагвадорж	Ердийн гишүүн	БиДиСек ХК-ийн тэргүүн дэд захирал	Дээд
7	Д.Нарангоо	Хараат бус гишүүн	Үнэмлэхүй эрх ХХК-ийн гүйцэтгэх захирал	Дээд
8	Т.Тамир	Хараат бус гишүүн	Амайзэ ХХК захирал	Дээд
9	Д.Түвшинтөгс	Хараат бус гишүүн	МУИС, Монгол хэл соёлын сургууль, багш	Дээд
10	Ж.Энхцэцэг	ТУЗ-ийн нарийн бичиг	Нако Түлш ХК-ийн ТУЗ-ийн нарийн бичиг	Дээд

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтанд хамрагдсан.

Компаний хувьцаа эзэмшигчдийн 2015 оны ээлжит хурлыг хуульд заасан хугацаа, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан журамд заасан шаардлагад нийцүүлэн “Нако

Түлш” ХК 2015 оны 04 сарын 16-ны өдөр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулж дараах асуудлыг шийдвэрлэсэн.

1. Компанийн 2014 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг хэлэлцэн батлах
2. Компанийн аудитын хорооны тайланг хэлэлцэн батлах
3. 2015 оны ажлын төлөвлөгөөг хэлэлцэн батлах
4. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
5. ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын 2015 оны зардлын төсвийг батлах
6. Компанийн ногдол ашгийн талаар гаргасан ТУЗ-ийн шийдвэрийг хэлэлцэн батлах

Хурлаар хэлэлцсэн асуудлуудыг хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн 100 хувийн саналаар баталсан.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар ТУЗ-ийн гишүүдийг сонгосон бөгөөд 2015 оны 04 сарын 16-ны өдөр Төлөөлөн Удирдах зөвлөлийн хурлыг хуралдуулан ТУЗ-ийн дэргэдэх хороодыг дараах бүрэлдэхүүнтэйгээр томилсон.

А. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Аудитын дэд хороог Т.Тамир, Д.Даянбилгүүн, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Аудитын хорооны даргаар ТУЗ-ийн хараат бус Т.Тамир гишүүнийг томилсон.

Б. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Цалин урамшууллын дэд хороог Грам Чэпмэн, Т.Тамир, Д.Түвшинтөгс гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Цалин урамшууллын дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Грам Чэпмэн-г томилсон.

В. Төлөөлөн удирдах Зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх дэд хороог Ж.Эрдэмбилэг, Т.Тамир, Д.Нарангоо гэсэн бүрэлдэхүүнтэйгээр байгуулан, Нэр дэвшүүлэх дэд хорооны даргаар ТУЗ-ийн гишүүн Ж.Эрдэмбилэгийг томилсон.